

МЭДЭЭЛЭЛ, СОНСГОЛ

Ш. Б. Чимиддоржиев
Г. Л. Балдаев

БУРИАД ДАХЬ МОНГОЛЫН СУДЛАЛ

Буриадын монгол судлал нь өөрийн баялаг түүх уламжлалтай юм. Тэндээс монголыг судлагч эрдэмтдийн хэд хэдэн үе төрж гарчээ. Орос оронд монголыг шинжлэх ухааны үүднээс судлах явдлыг хөгжүүлэх үйлсэд Д. Банзаров, Г. Гомбоев, Ц. Ж. Жамцарано, Г. Ц. Цыбиков нарын зэрэг буриад эрдэмтдийн оруулсан хувь нэмэр нийтэд илэрхий билээ. Эдний зэрэгцээгээр буриадад хувьсгалаас өмнө сонгодог монгол хэлээр эрдмийн бүтээлүүдээ нийтлүүлж тэр үеийн эрдэмтдийн хүрээнд нэр алдаршиж явсан дорно дахины (монголч) боловсролтой эрдэмтэд цөөнгүй байлаа.

Буриад дахь шинжлэх ухааны монгол судлалын хөгжилтөд 20—30-аад оны үед академич Б. Я. Владиморцов, профессор Б. Л. Котвич нарын зэрэг Ленинград, Москвагийн эрдэмтэд хувь нэмрээ оруулсан юм. Тэднээс буриадын эрдэм шинжилгээний боловсон хүчнүүд болох залуу эрдэмтэд, ахмад сэхээтнүүд ч заавар зөвлөлгөө авдаг байв.

30-аад оны дунд үеэр Бүгд Найрамдах Автономит Буриад Улсад эрдэм шинжилгээний залуу шинэ хүчнүүд нэмэн ирсэн нь Г. Н. Румянцев, К. М. Черемисов болон бас бусад дорно дахины судлалын их, дээд сургуулийг төгсгөсөн Б. Я. Владимирцовын шавь нар байв. Тэд монгол ба буриад судлалын асуудлыг аль алиныг нь судалж байжээ.

Тус Бүгд Найрамдах Улсад ЗСБНХУ-ын ШУА-ийн Сибирийн хэлтсийн буриад дахь салбар, түүний харьяанд 1971 онд монгол судлалын тасгийг байгуулснаас хойшхи арав гаруй жилийн дотор Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Автономит Буриад Улс дахь шинжлэх ухааны монгол судлал мэдэгдэхүйц хөгжлөө.

Буриад дахь эрдэм шинжилгээний байгууллагууд болон их, дээд сургуулиудад Ленинград, Москва, Улаан-Үд, Улаанбаатарт сургууль хийсэн онолын бэлтгэлтэй өндөр мэргэжлийн олон тооны монголч эрдэмтэд ажиллаж байна.

Буриадын монголч эрдэмтэд монголчуудын нэн эртнээс эдүгээ хүртэлх соёлын түүх, орос-монголын харилцаа, соёл шинжлэх ухааны салбарт ЗСБНХУ, БНМАУ хоёрын хамтран ажиллаж байгаа байдал, БНМАУ-ын хөдөө аж ахуйн социалист өөрчлөлт, Монголын хэл зохиолын асуудал, гар бичмэл болон модон барын судар бичгүүдийг судлах зэрэг олон чухал асуудлыг боловсруулж байна.

Аравдугаар таван жилийн төлөвлөгөөгөөр буриадын монгол судлагчид ЗСБНХУ ба БНМАУ-ын соёл, шинжлэх ухааны хамтын ажиллагаа, монгол гар бичмэл ба судрын судалгаа, тайлбар, тодорхойлолт, Орос ба ЗХУ-ын шинжлэх ухааны монгол судлалын түүх зэрэг асуудлыг боловсруулж байна.

Сүүлийн жилүүдэд монгол судлалаар хэд хэдэн томоохон эмхтгэл, ганц сэдэвт зохиолууд хэвлэгдэн гарлаа. Үүнд: «Монголын талаархи ма-

териал судалгаанууд» (өгүүллийн эмхтгэл), «Монголын түүх, хэлний шинжлэлийн судалгаа», «Алтан товч» (П. Б. Балданжавын орчуулга, тайлбар), Д. Б. Улымжиевын «БНМАУ-ын ардын боловсрол», Ш. Б. Чимиддоржиевын «Манжийн эсрэг монголын ард түмний чөлөөлөх тэмцэл», «XVII—XVIII зууны үеийн монгол, оросын харилцаа», Г. Н. Румянцев, Е. М. Залкин, Б. А. Цыбыков, Г. Н. Заятуев, К. М. Герасимова, Р. Е. Пубаев нарын зэрэг эрдэмтдийн монгол судлалын бүтээлүүд болно. Буриадын монголч эрдэмтэд, БНМАУ-ын эрдэмтдийн хамтран бэлтгэсэн «БНМАУ-ын соёлын түүхийн найруулал (1921-1970)» гэдэг зохиолыг 1971 онд хэвлэн гаргалаа. Энэ бүтээлийг зөвлөлтийн монгол судлалын эрдэм шинжилгээний чухал судалгаа гэж «Коммунист» (1972 оны № 13) сэтгүүлд академич А. П. Окладников үнэлэн бичсэн билээ.

Д-р Ц. Б. Цыдендамбаев «Буриадын түүхийн мэдээ, гарал судлал» гэдэг ганц сэдэвт зохиолдоо буриад судлалын асуудлаас гадна монголын ард түмний угсаатны гарал монгол-буриадын хэл аялгууны хэлхээ холбоог авч үзжээ. Буриадын монголч эрдэмтэд буриадын нийгмийн ухааны институт (БНУИ)-ийн дорно дахины судлалын бусад салбаруудтай хамтарч «Төв Азийн түүх, хэл шинжлэлийн материалууд» гэдэг эмхтгэлийн зургаан дугаарыг бэлтгэх ба хэвлэхэд оролцсон юм. Эдгээр бүтээлд Монголын түүх, философи, хэл, зохиолын асуудлаар бичсэн олон тооны өгүүлэл, мэдээ, шүүмж багтжээ.

БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн ойтой холбогдуулан 1974 онд хэвлэсэн Буриадын монголч эрдэмтдийн бүтээлүүд («Монголын талаархи материал судалгаанууд» эмхэтгэл, «Манжийн эсрэг монголын ард түмний чөлөөлөх тэмцэл» ганц сэдэвт зохиол)-ийн талаар БНМАУ-ын ШУА-ийн түүхийн хүрээлэнгийн захирал академич Ш. Нацагдорж өндөр үнэлэлт өсгөн юм. Түүнээс БНУИ-ийн захирлын нэр дээр ирүүлсэн захидалд: «Манай оронд Ардын Бүгд Найрамдах Улс тунхагласны 50 жилийн ойд зориулан эрдэм шинжилгээний сонирхолтой чухал бүтээлүүд хэвлэн гаргасан явдалд тань БНМАУ-ын түүхийн хүрээлэн гүн талархал илэрхийлж байна. Эдгээр зохиолууд нь монголын судлалыг хөгжүүлэхэд болон социалист Монголын ололт амжилтыг сурталчлах үйлсэд шинэ хувь нэмэр болох нь дамжиггүй» гэсэн билээ. Энэ онд Ш. Б. Чимиддоржиевын «Монгол ба Дундад Азийн харилцаа (XVII—XVIII)», Р. Л. Балдаевын «БНМАУ-ын ном зүй» (1961-1974), Г. Н. Румянце-вийн «Дундад зууны үеийн Монголын соёлын түүхийн талаархи материалууд», «Төв Азийн түүх, хэл шинжлэлийн талаархи материалууд»-ын 7 дахь гаралт, профессор Г. Ц. Цыбыковын зохиолын түүвэр хоёр ботиор, Е. О. Пинуевагийн «Гэсэрийн монгол хувилбаруудыг харьцуулсан судалгаа» бүтээлүүдийн гар бичмэл эхүүдийн зарим нь хэвлэгдэж зарим нь хэвлэлд бэлтгэгдэж байна. БНУИ-ийн гар бичмэлийн тасагт хадгалагдаж байгаа гар бичмэл ба модон барын монгол судар 3 мянгад эрдэм шинжилгээний тайлбар, тодорхойлолт хийх асар их ажлыг монгол судлалын тасгийн эрдэмтэд БНУИ-ийн гар бичмэлийн тасагтай хамтран гүйцэтгэжээ. Энэ бүтээл хэвлэлд бэлтгэгдэж байна.

1976 онд Улаанбаатарт хуралдсан олон улсын монголч эрдэмтдийн III их хуралд БНУИ-ээс 11 эрдэмтэд оролцсон явдал, мөн тэдний тавьсан илтгэлүүд Буриад дахь монгол судлалын амжилтыг гэрчилж байна. Тэдний илтгэлийн сэдэв нь олон талыг хамарсан байв. (ЗСБНХУ, БНМАУ-ын найрамдал ба соёлын хамтын ажиллагаа; монголчуудын эрхийн дурсгал бичиг «Халха Джирум»-ын хэл; Халх монгол хэл өмнөт буриадын ярианд нөлөөлсөн нь; Монгол хэлний эгшгийг шүргэлттэй болгох, XVIII—XX зууны үеийн монгол-буриадын утга зохиолын холбоо Гэсэрийн бичмэл эхүүд, Буриадын угсаатны бүтэц дахь монгол бүрэл-

дэхүүн хэсэг, Төв Азийн дундад зууны үеийн шинжлэх ухааны ангилал, Монголын ард түмний уламжлалт уран зураг гэх мэт болно).

Буриадын монголч эрдэмтэд шинжлэх ухааны монгол судлалын чухал асуудлуудыг судлахдаа БНМАУ-ын ШУА-ийн түүхийн хүрээлэн, хэл зохиолын хүрээлэн дорно дахины судлалын хүрээлэн, түүнчлэн монгол улсын их сургуулийн эрдэмтэдтэй бүтээлч холбоотой ажилладаг юм. «ЗСБНХУ ба БНМАУ-ын соёл, шинжлэх ухааны хамтын ажиллагаа» сэдвийг боловсруулахад Москва, Ленинградын монголч эрдэмтэд ба хэл шинжлэлийн ухааны д-р Л. К. Герасимович, түүхийн ухааны дэд эрдэмтэн Л. М. Гатауллина, д-р Д. Б. Улымжиев нарын зэрэг Улаан-Үдийн дээд сургуулиудын эрдэмтэн багш нар оролцож байна.

Бүгд Найрамдах Улсын монголыг судлагчид нь Монголын бичгийн дурсгалуудыг судлах талаар багагүй туршлагатай бөгөөд тухайлбал Г. Н. Румянцев, П. Б. Балданжапов нарын бүтээлүүдийг нэрлэж болно. Монголчуудын соёл (жишээ нь «БНМАУ-ын соёлын түүхийн найруулал») болон орос-монгол, зөвлөлт-монголын харилцаа, тэрчлэн хэл шинжлэлийн асуудлыг судлах талаар Буриадын эрдэмтэд нилээд үр бүтээлтэй ажиллаж байна.

БНУИ-ийн гар бичмэлийн тасаг монгол, буриад, хальмаг, манж хэл дээр бичигдсэн гар бичмэл ба модон барын баялаг сан хөмрөгтэй бөгөөд түүнийг товчоор «монгол фонд» гэнэ. Энэ фондод янз бүрийн материал байдаг. Ялангуяа тоо хэмжээ, үнэ цэнгийн хувьд гар бичмэл ба модон барын судар бичгүүд, түүнчлэн Буриад, Монголын түүх, эрхийн холбогдолтой баримт сэлтүүд илүү сонирхолтой байна. Ийм учраас БНУИ-ийн гар бичмэлийн тасгийн материал нь монгол судлалын эрдэм шинжилгээний сурвалж бичгийн дорвилог бааз болж чадна.

Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Автономит Буриад Улс ба түүний хөрш зэргэлдээ мужуудын архивт монголчуудын түүх, орос-монгол, зөвлөлт-монголын харилцаагаар сонирхолтой баримт бичгүүд багагүй байдаг юм. Хэрэв түүн дээр төв архивуудын материалыг нэмбэл монгол судлалын архив их баялаг сурвалж бичигтэй болно.

Буриад хэл монгол хэлний группэд багтдаг болохоор БНУИ-ийн хэл шинжлэлийн тасаг (хэлтэс)-ийн ажилтнуудын эрдэм шинжилгээний ажил нь монгол судлалын ажлын нэг хэсэг юм. Монголыг судлагч эрдэм шинжилгээний боловсон хүчнүүд ЗСБНХУ-ын ШУА-ийн Сибирийн хэлтсийн буриадын салбарын нийгмийн ухааны институт, Улаан-Үдийн дээд сургуулийн хэл утга зохиол, Буддизм, Төв Азийн судлалын зэрэг төрөл бүрийн тасаг хэлтэст ажиллаж байна. Монгол судлалын тасгийн ажилтнууд бол Бүгд Найрамдах улсын монголыг судлагчдын зөвхөн өчүүхэн хэсэг нь юм. Зөвлөлт Буриадын монголч эрдэмтдийн судалгааны цар хүрээ нилээд өргөн бөгөөд түүний дотор түүх, хэл бичиг, сурвалж зохиол судлал зонхилж байна. Үүнээс үзэхэд Буриадын болон ЗСБНХУ-ын ШУА-ийн Сибирийн хэлтсийн Буриадын салбарын шинжлэх ухааны монгол судлалын хөгжлийн төлөв нь юуны өмнө сурвалж зохиол судлалын чиглэл болно. Одоогийн байдлаар БНУИ-ийн гар бичмэлийн тасгийн монгол фондын цуглуулгад эрдэм шинжилгээний тодорхойлолт хийж байгаа бөгөөд түүнийг хэвлэх явдал нь дээрх гар бичмэл, модон барын судруудыг эрдэмтэд бүрэн ашиглах бололцоо олгоно. Монголын он дарааллын бичгийг судлах ажил үргэлжилж байна. «Цагаан түүх»-ийн орчуулга (П. Балданжав) дуусч, «Эрдэнийн товч»-ийн 8 бүлгийн орчуулга (Б. Цыбиков) хийгдсэн байна.

Орос дахь шинжлэх ухааны монгол судлалын түүх, монголын түүх бичлэг, сурвалж судлалын талаар материал цуглуулах талаар Р. Л. Балдаев, Д. Б. Улымжиев, Ш. Б. Чимиддоржиев нар ажиллаж байна. Бу-

риадын монгол судлалын хоёрдахь чиглэл нь нэн эрт үеэс өнөө хүртэлх үеийн монголчуудын соёлын түүхийг судлах явдал болно. Цаашдаа дундад зуун ба шинэ үеийн монголчуудын соёлыг тусгайлан судалж дуусгах нь чухал болно.

Гуравдугаар чиглэл нь Орос-Монгол, ЗСБНХУ-Монголын харилцааны судлал болно. XVII—XVIII зууны орос-монголын харилцаагаар ганц сэдэвт зохиол бэлтгэгджээ.

Одоо XIX зууны орос-монголын харилцааны зарим асуудлыг эрдэм шинжилгээний үүднээс судлан боловсруулах нь зүйтэй. Тэрчлэн зөвлөлт-монголын харилцааны асуудлыг судлах нь цаг үеийн чухал шаардлагатай сэдэв юм. Буриадын хэл шинжлэлчид монгол хэлний чухал асуудлуудыг шинжлэн судлах ажлаа үргэлжлүүлж байна.

Буриад дахь шинжлэх ухааны монгол судлалын өнөөгийн байдал, түүний хөгжилтийн ойрын ирээдүйн төлөв товчдоо ийм байна.

Оросоос орчуулсан **Э. Пунцаг**